



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 36

Мандалговь

Орон нутгийн өмчөөс төрийн өмчид хөрөнгө
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 5.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх хэсгийн тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сайхан-Овоо сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 71,600,000 /далан нэгэн сая зургаан зуун мянга/ төгрөгийн балансын үнэ, 31,265,222 /гучин нэгэн сая хоёр зуун жаран таван мянга хоёр зуун хорин хоёр/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Дэд станц, эрчим хүчний шугам (цахилгаан хангамжийн байгууламж), төрийн болон орон нутгийн өмчид бүртгэгдээгүй 1980 онд хийгдсэн эрчим хүчний 04 кв-ын 78 ширхэг 3330 метр шугам, 0.22 кв-ын 119 ширхэг 5355 метр шугамыг хавсралтын дагуу мэргэжлийн байгууллага болох “Эрдэнэт Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХКомпанийн харьяа “Өвөрхангай аймгийн Цахилгаан түгээх сүлжээ салбар”-ын өмчид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга), Сайхан-Овоо сумын Засаг даргын тамгын газрын дарга (С.Болоржаргал) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1. Цахилгаан хангамжийн барилга байгууламжийг балансаас балансад шилжүүлэх ажлыг зохих хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



СОД-ЭРДЭНЭ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн
36 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



Бүртгэлгүй хөрөнгийн мэдээлэл

Д/д	Барилга, байгууламжийн мэдээлэл	Зориулалт	Хүчин чадал		Ашиглал танд орсон огноо	Ашиглал тын нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримт лагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Хэмжих нэгж	Биет хэмжээ					
1.	0.4кв агаарын шугам	Цахилгаан гүйдэл дамжуулах	ш	78	1980	42	5,460,000	-	5,460,000
2.	0.22 кв агаарын шугам	Цахилгаан гүйдэл дамжуулах	ш	119	1980	42	8,330,000	-	8,330,000
Нийт							13,790,000 /арван гурван сая долоон зуун ерэн мянга/ төгрөг	-	13,790,000 /арван гурван сая долоон зуун ерэн мянга/ төгрөг

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн
36 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Сайхан-Овоо сумын ЗДТГ-ын балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1.	Цахилгаан дэд станц /шар эрэг/	2013	ш	1	22,200,000	22,200,000	18,685,000	3,515,000
2.	Цахилгаан дэд станц /Сэнжит хороолол/	2019	ш	1	20,400,000	20,400,000	2,108,000	18,292,000
3.	Дэд станц /Морин хөтөл/	2016	ш	1	29,000,000	29,000,000	10,472,222	18,527,778
Нийт						71,600,000 /далан нэгэн сая зургаан зуун мянга/ төгрөг	31,265,222 /гучин нэгэн сая хоёр зуун жаран таван мянга хоёр зуун хорин хоёр/ төгрөг	40,334,778 /дөчин сая гурван зуун гучин дөрвөн мянга долоон зуун далан найм/ төгрөг



ERDENEIT-BULGAN

ЭРДЭНЭТ-БУЛГАНЫ ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ӨВӨРХАНГАЙ САЛБАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,

Утас/Факс: 7032 2176,

И-мэйл: uv_erchim@mongol.net


2021.12.06 № 1/82

танай 2021.10.28 -ны № 1/110 -Т

Дундговь аймгийн Сайхан-Овоо
сумын засаг дарга танаа

Танай байгууллагаас ирсэн албан бичгийг
хүлээн аваад хариуг хүргүүлж байна. Үүнд:

Манай байгууллагын зүгээс татгалзах
зүйлгүй бөгөөд Төрийн өмчийн бодлого
зохицуулалтын газарт хүсэлтээ гаргаад асуудлыг
шийдвэрлүүлнэ үү.

ДАРГА  Б. ДЭМБЭРЭЛСАЙХАН

